


Өвлийн саруудад Монгол орны нутаг дэвсгэр дээгүүр их даралтын орон зонхилон ажиглагддагтай холбоотой цаг агаар гол төлөв тогтуун байдаг. Манай орны 2 дугаар сарын агаарын дундаж температур (1991-2020 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон томоохон гол, нуурын сав газраар -18°C (-0.4°F) –аас хүйтэн, говь-цөлийн бүс нутгаар -6°C (21.2°F) –аас -12°C (10.4°F), бусад нутгаар -12°C –аас -18°C (20.4°F –аас -0.4°F) хүйтэн байдаг байна.


Монгол орны хэмжээнд 2 дугаар сард хур тунадас бага унадаг ба ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 1 хувьтай тэнцдэг. Тус сард томоохон гол, нуурын сав газар болон Увс, Хэнтийн баруун, Завханы хойд хэсгээр 3-4 мм, говь цөлийн бүс нутгаар 0.3-1.4 мм бусад нутгаар 1.5-3 мм тунадас ордог байна.



Зураг 1. 1991-2020 оны 2 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны газарзүйн тархалт


2023 оны 2 дугаар сарын агаарын дундаж температур өмнөх жилээс 4.8°C -аар, ОЖД-аас 2.1°C -аар дулаан байсан бөгөөд 1940 оноос хойш тохиолдож байгаа 12 дахь дулаан сар болж өнгөрлөө. Сарын дундаж агаарын температурын ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзэхэд (Зураг 2) нутгийн дийлэнх 80.6% нь ОЖД-аас 1.1 –ээс 5.3°C -аар дулаан, 17.1% нь ОЖД-ийн орчим, харин 2.3% нь ОЖД-аас хүйтэн байжээ.

Тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 1.5 мм хур тунадас орсон нь өмнөх жилтэй ойролцоо, харин ОЖД-аас 21.8%-иар бага буюу 1940 оноос хойш тохиолдож байгаа 38 дахь бага тунадастай сар болж өнгөрлөө. Сарын нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын орон зайн тархалтыг авч үзвэл (Зураг 2) нийт нутгийн 30.2% нь дунджаас ахиу, 62.0% нь дунджаас бага, 7.8% -д ОЖД-ийн орчим хур тунадас унасан байна.




Зураг 2. 2023 оны 2 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын газарзүйн тархалт

Монгол орноор болон 4 бүсээр хуваан дунджилсан 2 дугаар сарын хоногийн дундаж агаарын температурын явцыг авч үзэхэд ихэнх хугацаанд ОЖД- аас дулаан (Зураг 3), ялангуяа 3 дугаар арав хоногт бүх нутгаар эрчимтэй дулааралт (2-оос +11.2°C-аар) ажиглагдсан байна. Харин баруун болон төвийн бүс нутгаар 2 дугаар 10 хоногт ОЖД-аас -1.1-аас -2.8°C хүйтэн байжээ. Хур тунадасны хувьд баруун болон өмнө, төвийн бүс нутгаар 1 болон 2 дугаар 10 хоногт харьцангуй ахиу, харин зүүн бүс нутгаар ихэнх хугацаанд хур тунадас бага орсон байна.



Зураг 3. Хоногийн дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Энэ сард агаарын температурын үнэмлэхүй их утга Баянхонгорын Эхийнголд 13.8°C, үнэмлэхүй бага утга Завханы Баян-Уулд -42.0°C, хөрсний температурын үнэмлэхүй их утга Говь-Алтайн Ажбогдод 27°C, үнэмлэхүй бага утга Завханы Нөмрөгт -44°C хүрч хүйтэрсэн байна. Хоногт хамгийн ихдээ Говь-Алтайн Бугат суманд 13-ний өдөр 7.9 мм тунадас орсон. Харин даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 966.7гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 759.2гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Говь-Алтайн Бугатад 28 м/с хүрчээ.



Зураг 5. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд